



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/110

Батноров сум

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа
Хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн
нэг гишүүнд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалт, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн эрх шилжүүлэх гэрээ, хэлцлийг харгалзан Дундбүрд багийн Жавхлант гудамжны 313 тоот хаягт байрлах 1532 м² газрыг дурдсан О.Навчсайханд үнэ төлбөргүй шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2. Гэр бүлийн нэг гишүүний өмчилж авсан газарт энэхүү захирамжийг үндэслэн газрын кадастр хийх, газар өмчлөгчид хүлээлгэн өгөх, хилийн заагийг газар дээр нь тэмдэгжүүлэх, улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Э.Зулцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Батноров сумын Засаг даргын 2017 оны А/136 захирамжийн 34 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Газраа шилжүүлсэн иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ДАРГА



Г.ОТГОНБАЯР